

БАТЛАВ:
БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА /Г.ЭНХМӨНХ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ХАНБОГД ВЕЙСТ МЕНЕЖМЕНТ ЦЕНТР “ ХХК-НИЙ ЗАХИРАЛ Ц.ОЮУНДАРЬ

Төсөл хэрэгжүүлэгч: “ХАНБОГД ВЕЙСТ МЕНЕЖМЕНТ ЦЕНТР” ХХК

**“Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал болон энгийн хог
хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах”
төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:3627373/

Боловсруулсан:
“Ханбогд вейст менежмент центр “ ХХК-ний мэргэжилтэн /Б.Баянтогтох/

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төслийн танилцуулга.....	7
1.3. Технологи, хүчин чадал.....	8
1.4. Ландфилл хийхэд ашиглах техник	10
1.5. Төслийн барилга байгууламж	14
1.5.1. Төслийн дэд бүтцийн шийдэл	15
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	25
3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	25
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	28
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	37
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	38
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн булангийн цэгүүд	5
Хүснэгт 2. Ахуйн хог хаягдлын дотор нь ангилан хувиар илэрхийлбэл	7
Хүснэгт 3. Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадлын үзүүлэлт	10
Хүснэгт 4. Хадгалах аюултай хог хаягдлын жагсаалт	11
Хүснэгт 5. Устгалд оруулах аюултай хог хаягдлын жагсаалт	13
Хүснэгт 6. Ханбогд сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт	19
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	25
Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл	28
Хүснэгт 9.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30
Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	33
Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	34
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	35
Хүснэгт 13. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	37
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь	38
Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	39
Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	6
Зураг 2. Ерөнхий төлөвлөлийн зураг	14
Зураг 3. Төслийн талбайн фото зураг №1	14
Зураг 4. Төслийн талбайн фото зураг №2	15
Зураг 5. Төслийн барилга байгууламжийн дотор тал	15
Зураг 6. Ууршуулах цөөрөм	15
Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу	17
Зураг 8. Ханбогд сумын уур амьсгалын горим	19
Зураг 9. Ханбогд сумын салхины сарын хурд	20
Зураг 10. Төслийн талбайн районы гадаргын ус	21
Зураг 11. Төслийн талбайн ургамалжилт	23

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	■ Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал болон энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, устгах төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	■ “Ханбогд Вейст Менежмент Центр” ХХК - Улсын бүртгэлийн дугаар: 1111010023 - Регистрийн дугаар: 3627373
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:	Өмнөговь аймаг, Ханбогд сум, 2-р баг, Гавилуут, Гоёот 4-4 тоот
Төслийн зорилго:	■ Хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвийн айл өрх, албан байгууллагуудын хог хаягдлын хэмжээг бууруулж, аюултай хог хаягдалд хяналт тавих, хэрэглээг багасгахад оршино. Орчин үеийн техник технологийг ашиглан боловсруулалтад оруулснаар байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн түүхий эдийг бэлтгэж хог хаягдлыг эдийн засгийн үр өгөөжтэйгөөр ашиглах үндсэн зорилготой. ■ Бид энэхүү төслийг цуглуулах, ангилан ялгах, дахивар бүтээгдэхүүний дахин боловсруулах үйлдвэрт хэрэгжүүлэхдээ дараах зорилтуудыг тавин ажиллана. Зорилт 1. Айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагуудын нийт хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах. Зорилт 2. Дахин боловсруулах хог хаягдлыг сайтар ангилан ялгаж байгаль орчин ээлтэй технологи ашиглан ахуйн хог хаягдлыг булшлах. Зорилт 3. Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан төлбөр тооцоог тогтоон ажиллана. Үүний хүрээнд Зорилт 4. Ханбогд суман дахь өөрийн байранд эрүүл мэндийн байгууллагуудын аюултай халдвартай хог хаягдлыг халдваргүйжүүлэн устгах тоног төхөөрөмж байршуулан хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана. Төлбөрийг ЭМС А/605 тоот аргачлалын дагуу тооцож авна. ■ Мөн эрүүл мэндийн байгууллагаас гардаг эхэс, эмгэг хог хаягдлыг тусгай зориулалтын доторлогоотой саванд хийж ууршуулах аргаар боловсруулна Зорилт 5. Орон тоогоо нэмэгдүүлж ажлын байр шинээр бий болгоно.

Төслийн байршил


“Ханбогд Вейст Менежмент Центр” ХХК-ийн “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал болон энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, устгах” төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, 4-р багийн нутагт байрлана. Ханбогд сумын төвийн зүүн хойно 5 км зайд, Дөрвөлж уулын баруун талд, Оюутолгой уурхайгаас 45 км зайд байрлана.

- Талбайн хэмжээ: 5000 м²
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: К-48-35

Газарзүйн солбицол

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	107	12	45.1	43	14	24.5
2	107	12	46.5	43	14	25.4
3	107	12	49.4	43	14	22.8
4	107	12	47.6	43	14	21.8



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг

1.2. Төслийн танилцуулга

“Ханбогд вейст менежмент центр” ХХК нь аймаг орон нутагт хог хаягдлын менежментийг сайжруулах, орон нутгийн энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, энгийн хог хаягдал болон аюултай хог хаягдлыг хяналтанд оруулж ангилан ялгаж дахин боловсруулах, аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагуудад ангилан ялгалтын сургалт явуулах, дахин боловсруулагчидтай гэрээ хийж тээвэрлэх, байгаль орчин хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүй байдлаар шийдвэрлэнэ.

Ханбогд сумын айл өрх, хүн ам, албан байгууллага нь уул уурхайн хөгжил дэвшил, үйл ажиллагааг дагаад жилээс жилд өсөж байгаагийн хэрээр хог хаягдлын хэмжээ ч даган нэмэгдэж байгаа талаар дээр дурдсан билээ. Статистик үзүүлэлтээс харахад хүн хоногт дунджаар 0,5 кг, жилд 190 кг хог хаягдал үүсгэдэг байна. Энэ нь хүрээлэн байгаа орчныг бохирдуулах, сумын өнгө үзэмж тохижилт хийгээд таван хошуу мал, говийн ховор амьтан, ургамал, ард иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг юм. Хэдийгээр төр захиргааны байгууллага болон хувийн аж ахуй нэгжүүд хог хаягдлыг бууруулах, устгах чиглэлээр олон үйл ажиллагаа явуулж байгаа боловч эдгээр нь төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Хог хаягдлын судалгаанаас үзэхэд 89 хувь нь ахуйн, 9.5 хувь нь барилгын, 1.2 хувь нь аюултай хог хаягдал, 0.1 хувь нь эмнэлгийн хог хаягдал байна. Эдгээр хог хаягдлын дийлэнх хувийг эзлэх ахуйн хаягдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Ахуйн хог хаягдлын дотор нь ангилан хувиар илэрхийлбэл

Ангилал	Бүтцийн хувь хэмжээ /%/	Хогны хэмжээ /гр/хүн/өдөр/
Хүнсний хаягдал	8.97	81.7
Цаас	1.23	11.2
Даавуу	0.68	6.2
Өвс, мод	0.05	0.5
Хуванцар	1.7	15.5
Резин, савхи	0.04	0.4
Төмөрлөг	0.31	2.8
Шил, лонх	1.73	15.8
Шаазан, чулуу	0.45	4.1
Бусад	2.81	25.6
Үнс	82.02	747
Бүгд	100.0	910.8

“Ханбогд Вейст Менежмент Центр” ХХК-ий дэвшүүлж байгаа уг хог хаягдлыг ангилан ялгаж, системтэйгээр боловсруулж эдийн засгийн эргэлтэнд оруулах, өндөр хөгжилтэй улс орнуудын хаягдал боловсруулах орчин үеийн технологийг эх орондоо хэрэгжүүлэх зорилготой төсөл юм. Мөн төсөл хэрэгжсэнээр өнөөгийн хог хаягдлын талаарх нөхцөл байдлыг өөрчилж, хаягдал дахин боловсруулах хэмжээний үйлдвэрлэлж байгаа уг хог хаягдлыг ангилан ялгаж, систем **Төсөл хэрэгжиж эхэлснээр бий болох давуу талууд:**

- ✓ Өмнөговь аймаг Ханбогд сумын төвийн хог хаягдлыг бууруулах асуудалд өөрсдийн хувь нэмрээ оруулна;

- ✓ Хог хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүний түүхий эдийг үйлдвэрлэнэ. Дахин боловсруулсан түүхий эдээр, барилгын материал, хогийн сав, сандал, дэлгүүрийн сагс, хайс, хувцас зэрэг олон зүйлийг хийх боломжтой;
- ✓ Өндөр хөгжилтэй орнуудын хаягдлын менежмент болон хаягдал боловсруулах технологийг өөрийн эх орондоо хэрэгжүүлнэ;
- ✓ Хог хаягдлын талаарх иргэдийн ойлголтыг өөрчилж зөв дадал хэвшилд төлөвшүүлнэ. Ингэхийн тулд иргэдэд ойр, үйлчлүүлэхэд хялбар хаягдал хүлээн авах цэгүүдийг олноор байгуулж хог хаягдлыг эдийн засгийн үр өгөөжтэйгөөр ашиглах боломжийг олгоно;
- ✓ Хог хаягдлыг боловсруулах, устгахтай холбогдон гарах зардлыг бууруулна;
- ✓ Аюултай хог хаягдалд хяналт тавих;
- ✓ Аюултай хог хаягдлын хэрэглээ, байгальд хаягдсанаар үүсэх хор уршиг, сөрөг нөлөө, аюулыг бууруулна;
- ✓ Сургалт явуулснаар айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллага нь хог хаягдлын ангилал ялгалтын мэдлэгтэй болох, энгийн болон дахивар хаягдлаар ангилах, аюултай хог хаягдлын аюулыг мэдэж авах;
- ✓ Ажлын байр шинээр бий болно;
- ✓ Хог хаягдал булшлах талбай (ландфилл)-ын үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй техник технологи ашиглан явуулна;

1.3. Технологи, хүчин чадал

Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагуудтай аюултай хог хаягдлын ангилан ялгалт, хор уршиг, аюул, зөв хэрэглээ, хог хаягдал бууруулах арга зам сэдвээр сургалт зохион байгуулах, мөн гэрээ байгуулж ангилан цуглуулсан аюултай дахивар бүтээгдэхүүнийг зориулалтын зөвшөөрөл бүхий техникээр тээвэрлэх юм.

Хүчин чадал

- Ханбогд сумаас айл өрх, албан байгууллагаас жилд 28000 тн хог хаягдал хүлээж авна хэмээн төлөвлөсөн;
- Дахин боловсруулах хог хаягдлыг ачилтад бэлдэн 200-300 кг хэмжээтэйгээр пресслэнэ;
- Автоклавт эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэлт хийж, хоногт 4 тонн хог хаягдлыг халдваргүйжүүлэнэ;
- Хог хаягдлыг бутлах бутлагч хоногт 1.5-3 тн хог хаягдлыг бутлана;

Ажиллах горим

- | | |
|------------------------------|------------|
| - Жилд ажиллах хоног | - 365 өдөр |
| - Сард ажиллах хоног | - 30 өдөр |
| - Хоногт ажиллах ээжлийн тоо | - 1 ээлж |
| - Хоногт ажиллах цаг | - 24 цаг |

Төслийн ажиллах хүч

Энэхүү төслийн талбайд нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллана. Үүнд:

- Оператор: ландфиллын үйл ажиллагааг бүхэлд нь хариуцан ажиллана. Хог хаягдал

- булшлах талбай, хог хаягдал булшлах үйл явц;
- Туслах ажилтан: хог хаягдлын төвлөрсөн байгууламжид ирсэн хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах, дахин боловсруулах хог хаягдлыг пресслэх үйл ажиллагааг хариуцан ажиллана;

Энгийн хог хаягдал

Айл өрхийн болон албан байгууллагаас гарч буй хог хаягдал болон дахин боловсруулж болохгүй холимог материалыг дараах үйл ажиллагаагаар зохицуулна. Үүнд:

1. Хог хаягдлын төвлөрсөн цэг буюу ландфиллд зайлуулсан айл өрхийн болон албан байгууллагаас гарч буй ахуйн холимог хатуу хог хаягдал болон дахин боловсруулж болохгүй материалыг булшилна.
2. Ландфиллийн ажлын талбайд хүлээн авах хог хаягдлын ангилан ялгалтын чанарт хаягдал хүлээн авах ажилтнаас гадна ландфилл хариуцсан оператор мөн хяналт тавьж ажиллана.

Дахин боловсруулах материал агуулсан холимог хатуу хог хаягдал

Ахуйн холимог хатуу хог хаягдал нь эх үүсвэр дээр нь зохих журмын дагуу ангилаагүй, дахин боловсруулах боломжтой хог хаягдлаас бүрддэг. Энэ хаягдалд цаас, картон, хуванцар сав, ашигласан техникийн тос, тостой арчих материал, химийн бодисын хоосон сав, бусад дахин боловсруулах ангиллын хог хаягдал багтана.

Бид хог хаягдлыг аль болох дахин ашиглах, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Иймд хог хаягдлыг аль боломжит хэмжээгээр ангилан ялгаж дахин боловсруулах болон дахин ашиглах чиглэлээр үйлдвэрүүдэд хүлээлгэн өгнө.

- Дахин боловсруулах хог хаягдлыг ачилтад бэлдэн **200-300 кг** хэмжээтэйгээр пресслэнэ.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын удирдлага нь доорх үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хүлээж авч тээвэрлэх.
- ЭМБ-ын аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх автоклавт хүргэх хүртэл хаягдал хүлээн авах хэсэгт аюулгүй, найдвартай байдлаар хадгална.
- ЭМБ-ын аюултай хог хаягдлыг байгууламжид хүлээж авснаас хойш 72 цагийн дотор ариутган халдваргүйжүүлэлт хийж буталж булсан байна.
- Автоклавыг үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмжийн дагуу эмнэлгийн хог хаягдлыг ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд бэлтгэнэ.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх, ариутган халдваргүйжүүлэх, бутлах тоног төхөөрөмжүүд

Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл - Эрүүл мэндийн байгууллагаас гарч буй аюултай хог хаягдлыг тусгай таних тэмдэгтэй, бүхээгтэй, зориулалт бүхий тээврийн хэрэгслээр зөөж тээвэрлэнэ.

Автоклав: Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэлт хийх зориулалттай. Ариутгалын төхөөрөмж нь өндөр даралтад усны уураар ажиллана. 121-131⁰С-т 30-40 минутанд нэг удаад дунджаар 100 кг хог, өдөрт **4 тонн** хог хаягдлыг халдваргүйжүүлэх хүчин чадалтай олон улсын стандартад нийцсэн төхөөрөмж юм.

Хог хаягдлыг бутлах бутлагч: Автоклавт халдваргүйжүүлсэн болон бусад хог хаягдлын овор хэмжээ, байгальд хурдан задрах процессыг нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах зорилгоор буталж жижиглэх зориулалттай. Цагт 250 кг, өдөрт **1.5-3 тонн** хог хаягдлыг бутлах хүчин чадалтай.

1.4. Ландфилл хийхэд ашиглах техник

Универсаль – хог хаягдлын төвлөрсөн цэгт буусан хог хаягдал болон шороог түрж тэгшлэх, дагтаршуулахад зориулан бэлтгэх зориулалттай тоног төхөөрөмж юм.

Дахивар бүтээгдэхүүний овор хэмжээг багасгаж тээвэрлэлтийн зардлыг хэмнэх зорилготой пресслэгч байршуулах. Харин бусад тээврийн хэрэгслүүдийг бид өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан одоо ашиглаж байгаа авто машинуудаа эхний ээлжинд ашиглахаар төлөвлөөд байна. Энэ менежментийн төсөлд ашиглагдах техник, тоног төхөөрөмж болно.

Хүснэгт 3. Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадлын үзүүлэлт

№	Тоног төхөөрөмжийн нэр, номер	Зориулалт	Зураг
1	Пресслэгч машин	Дахивар хаягдал цаас, хуванцар усны сав пресслэх машин	
2	Автоклав / Siemens/	Эрүүл мэндийн байгууллагын аюултай халдвартай хог хаягдал ариутгах төхөөрөмж	
3	Ууршуулах доторлогоотой сав	Эрүүл мэндийн байгууллагаас гардаг эхэс, эмгэг хог хаягдлыг ууршуулах зориулалтын сав	

№	Тоног төхөөрөмжийн нэр, номер	Зориулалт	Зураг
4	Ковш	Хог хаягдал булшлах, зөөх техник	

4.3.2. Хог хаягдал хадгалалт, устгах

Хүснэгт 4. Хадгалах аюултай хог хаягдлын жагсаалт

№	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
13 01	Гидравлик тосны хаягдал	13 01 01*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан гидравлик тос	А
		13 01 02*	Хлор агуулсан эмульс	А
		13 01 03*	Хлор агуулаагүй эмульс	А
		13 01 04*	Хлор агуулсан эрдсийн гидравлик тос	А
		13 01 05*	Хлор агуулаагүй эрдсийн гидравлик тос	А
		13 01 06*	Нийлэг гидравлик тос	А
		13 01 07*	Биоадралд түргэн ордог гидравлик тос	А
		13 01 08*	Бусад төрлийн гидравлик тос	А
13 02	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	13 02 01*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны хлор агуулсан эрдсийн тос	А
		13 02 02*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны хлор агуулаагүй эрдсийн тос	А
		13 02 03*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны нийлэг тос	А
		13 02 04*	Биоадралд түргэн ордог хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тос	А
		13 02 05*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос	А
13 03	Тусгаарлагч, дулаан дамжуулах тосны хаягдал	13 03 01*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан тусгаарлагч болон дулаан дамжуулагч тос	А
		13 03 02*	Хлор агуулсан тусгаарлагч болон дулаан дамжуулагч эрдсийн тос (13 03 01-д зааснаас бусад)	А
		13 03 03*	Хлор агуулаагүй тусгаарлагч болон дулаан дамжуулагч эрдсийн тос	А
		13 03 04*	Нийлэг тусгаарлагч болон дулаан дамжуулагч тос	А

№	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
		13 03 05*	Биозадралд түргэн ордог тусгаарлагч болон дулаан дамжуулагч тос	А
		13 03 06*	Бусад төрлийн тусгаарлагч болон дулаан дамжуулагч тос	А
13 04	Ус, тос ялгах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	13 04 01*	Элсэн шүүлтүүр болон тос, ус ялгагчаас гарсан хатуу хаягдал	А
		13 04 02*	Тос, ус ялгагчаас гарсан лаг	А
		13 04 03*	Тос баригчаас үүсэх лаг	А
		13 04 04*	Тос, ус ялгагчаас үүсэх тос	А
		13 04 05*	Тос, ус ялгагчаас үүсэх тосорхог ус	А
		13 04 06*	Элсэн шүүгч болон тос, ус ялгагчаас гарсан холимог хаягдал	А
13 05	Шингэн түлшний хаягдал	13 0 501*	Түлшний тос, дизель	А
		13 0 502*	Бензин	А
		13 0 503*	Бусад түлш (холимог түлш орно)	А
16 01		16 01 04*	Тосны шүүр	А
		16 01 10*	Тоормосны шингэн	А
		16 01 11*	Аюултай нэгдэл агуулсан антифризийн шингэн	Х
16 07	Зөөврийн танк, шингэн хадгалах танк, торхны цэвэрлэгээний хаягдал (Д ба М бүлгийн хаягдал хамаарахгүй)	16 07 01*	Тос агуулсан хаягдал	Х
		16 07 02*	Бусад төрлийн хортой бодис агуулсан хаягдал	Х
19 08	Хаягдал ус цэвэрлэх байгууламжаас үүсэх бусад хог хаягдлууд	19 08 04*	Ханасан буюу ашигласан ион солилцооны материал	А
		19 08 05*	Ион солилцооны материалыг цэнэглэхэд үүссэн уусмал болон лаг	А
		19 08 08*	19 08 07-д зааснаас бусад тос/усыг салгах процессоос гарсан өөх тосны хольц	А
		19 08 09*	Үйлдвэрийн хаягдал усны биологийн цэвэрлэгээнээс үүссэн хортой бодис агуулсан лаг	Х
		19 08 11*	Үйлдвэрийн хаягдал усны бусад цэвэрлэгээнээс үүссэн хортой бодис агуулсан лаг	Х

Хүснэгт 5. Устгалд оруулах аюултай хог хаягдлын жагсаалт

№	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
18 01	Хүний эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, төрөлт болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	18 01 02*	Эмгэг хог хаягдал (хүний биеийн эд эрхтэн, хэсэг болон цус, цусан бүтээгдэхүүн, нөөцөлсөн цус (18 01 03-д зааснаас бусад))	А
		18 01 03*	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал	А
		18 01 05*	Хортой бодис агуулсан химийн бодисын хаягдал	Х
		18 01 07*	Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал (Цитотоксик, цитостатик эм гэх мэт)	А
		18 01 09*	Шүдний эмнэлгийн амальгам хаягдал	А
		18 01 10*	Халдвартай шингэн хаягдлын анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх лаг	А
18 02	Мал, амьтны эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	18 02 02*	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал	А
		18 02 04*	Хортой бодис агуулсан химийн бодисын хаягдал	Х
		18 02 06*	Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал (Цитотоксик, цитостатик эм гэх мэт)	А
20 01		20 01 19*	Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал (цитотоксик, цитостатик эм гэх мэт)	А

1.5. Төслийн барилга байгууламж



- | | |
|---------------------------------------|--|
| 1.Хог хаягдлын удирдлагын төв | 7.Боловсруулах хог хаягдал хадгалах талбай |
| 2.Тогооны барилга | 8.Хаягдал хадгалах талбай |
| 3.Гүний худаг | 9.Харуулын байр |
| 4.Сагсан бөмбөгийн талбай | 10.Ландфиллын талбай |
| 5.Ажилчдын амралтын байр, цайны газар | 11.Дэд өртөө |
| 6.Ажилчдын ариун цэврийн өрөө | 12.Машин ариутгах хэсэг |

Зураг 2. Ерөнхий төлөвлөлийн зураг



Зураг 3. Төслийн талбайн фото зураг №1



Зураг 4. Төслийн талбайн фото зураг №2



Зураг 5. Төслийн барилга байгууламжийн дотор тал



Зураг 6. Ууршуулах цөөрөм

1.5.1. Төслийн дэд бүтцийн шийдэл

- **Усан хангамж:** Хандизель ОНӨААТҮГ газар-тай байгуулсан 2021 оны 12-р сарын 08-ны өдрийн 01 дугаартай цэвэр ус нийлүүлэх гэрээний дагуу зөөврөөр хангана;
- **Цахилгаан хангамж:** Төвлөрсөн эх үүсвэрээс хангана;
- **Дулаан хангамж:** Хийн зуухаар халаана;
- **Бохир:** Бохир усыг зориулалтын ёнкоост хуримтлуулан Хандизель ОНӨААТҮГ газар-тай байгуулсан 2021 оны 12-р сарын 09-ны өдрийн 43 дугаартай бохир ус соруулах, тээвэрлэх гэрээний дагуу тухай бүр нь соруулна;
- **Харилцаа холбоо:** Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;


2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадаргуу: Өмнөговь нь газар нутгийн хэмжээгээрээ Монгол улсдаа хамгийн том аймаг юм. Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.


Хадат, Нэмэгт, Зөөлөн, Энгэр бүлээн, Талхит зэрэг олон хүйтэн рашаан, Элгэн, Салхитын халуун рашаан устай.

Далайн түвшнээс дээш 800-1000 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Говь Алтайн нурууны захын уулсын мужид багтдаг. Сумын нутаг дэвсгэр нь говь цөлийн бүсэд хамаарна. Газар хөдлөлийн эрчим 8 балл. Сумын нутаг дэвсгэр нь ухаа гүвээ, цав толгод бүхий тал хээр, мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой ба харин газар тариалан эрхлэхэд тохиромж муутай.

Ханбогд сум нь баруун хойд талаараа Цогтцэций, баруун талаараа Баян Овоо, хойд талаараа Манлай, Зүүн талаараа Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдтай хиллэдэг бөгөөд харин урд талаараа БНХАУ-тай хиллэн оршдог Өмнөговь аймгийн хамгийн зүүн урд захын сум юм. Улаанбаатар хотоос 650 км, Аймгийн төвөөс 250 км зайд байрладаг.



Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу



Зураг . Төслийн талбайн районы өндөршил


Цаг уур, уур амьсгал: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь Төв Азийн хуурай, хуурайдуу говь, цөлийн бүсэд багтана. Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөргийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрснөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.

Бид энэхүү судалгаандаа Өмнөговь аймгийн Ханбогд сумын уур амьсгалыг тодорхойлоход “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн Ханбогд станцын 1981-2010 оны Уур амьсгалын норм буюу уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтүүд мөн 2017-2019 оны сарын дундаж агаарын температур, хур тунадас болон салхины мэдээ материалуудыг ашиглав.

Хүснэгт 6. Ханбогд сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Сарын дундаж агаарын температурын үзүүлэлтүүд													
Дундаж	-11.5	-7.3	-0.4	9.1	16.6	22.4	24.9	22.6	16.7	8.2	-2.1	-9.3	7.5
Үнэмлэх их температур	9	13.2	24.3	33	36.5	40.5	42.2	39	35.2	26.9	18.8	11.9	42.2
Үнэмлэх бага температур	-28.6	-28.6	-22.1	-13	-6	4.7	10.6	7.2	-3.1	-13.5	-23.1	-27.6	-28.6
Сарын нийлбэр хур тунадасны үзүүлэлтүүд													
Нийлбэр	1.2	1.3	2.9	3.4	8.7	13.2	24.4	27.4	8.9	3.2	1.3	0.9	97.4
Хамгийн их	401	6.5	20.4	16.3	73.6	56.8	75.8	80.4	50.7	19.1	9.3	7.1	80.4

Ханбогд сумын сүүлийн жилүүд буюу 2018-2020 оны хоорондох дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур $+8.0...+8.7^{\circ}\text{C}$ бөгөөд өвлийн улиралд $-10.9...-8.2^{\circ}\text{C}$, хаврын улиралд $-3.8...+17.9^{\circ}\text{C}$, зуны улиралд $+22.7...+25.4^{\circ}\text{C}$ харин намрын улиралд $-0.7...+17.5^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзсэн байна.




Зураг 8. Ханбогд сумын уур амьсгалын горим

Тунадасны жилийн явц газарзүйн онцлогоос хамаарч харилцан адилгүй мөн улирлын ялгаа ихтэй байдаг. Тухайн бүс нутагт жилийн нийлбэр хур тунадасойролцоогоор

104.1...209.2 мм-ийн хооронд унадаг. Үүнээс өвлийн улиралд 0.1. 2.8 мм, хаврын улиралд 2.8...7.6 мм, зуны улиралд 4.7...45.5 мм, намрын улиралд 0.15...22.7 мм хэмжээтэй хур тунадас унадаг байна. Тус бүс нутгийн хувьд хамгийн их хур тунадас 8 сард дунджаар 45.5 мм, хамгийн бага хур тунадас 11 сард 0.15 мм орчим унажээ.

Гадаргын онцлог, агаарын массын улирлын шилжилт циклон ба эсрэг циклоны солигдох байдал зэргээс үүдэн Монгол оронд салхи ихтэй байдаг. Түүнчлэн салхины горимын үндсэн үзүүлэлт болох салхины хурд ба зүг чиг нутаг бүрд харилцан адилгүй байдаг. Ийм 2018-2020 оны хоорондох салхины хурдыг зураг 9-д үзүүлэв.




Зураг 9. Ханбогд сумын салхины сарын хурд

Ханбогд сумын нутагт жилийн дундаж салхины хурдны хэмжээ 4.5 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр тохиож байна. Сарын дундаж салхины үндсэн хамгийн их утга нь 5 сард 5.1 м/с, хоёрдугаар их утга нь 10 сард 4.6 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 8 сард 3.7 м/с, хоёрдугаар бага утга нь 2 сард дунджаар 4.1 м/с тохиосон байна.

Усан сүлжээ: Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтана.

Гол мөрний олон жилийн дундаж урсцын модуль нэн бага буюу 1 км² -аас бага (түр урсгал бүхий гол горхины мужид багтдаг), олон жилийн дундаж урсцын давхраа 25-ээс бага 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсцын модуль тус тус 0.1 м³/км-ээс бага (түр урсгал бүхий гол горхины муж) байна. Сумын нутагт тогтмол урсацтай томоохон гол мөрөн байхгүй.

Ханбогд сум нь ус зүйн хувьд Галба-Өөш-Долоодын говь голын сав газарт хамаарагддаг. Энэхүү сав газар нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн 33.13 %-ийг хамарна.



Зураг 10. Төслийн талбайн районы гадаргын ус


Хөрсөн бүрхэвч: Хөрсний хээрийн болон суурин судалгааны үр дүнгээр төслийн талбайд бүхэлдээ элсэрхэг говийн бор хөрс тархсан байна. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ бага, хялбар уусах давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж маш бага, хөдөлгөөнт калийн хангамж бага байна.

Ургамлан нөмрөг: Ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна. (Өлзийхутаг, 1989). Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог нь далайн түвшнээс дээш 850-1400 метрт оршино. Дорноговийн тойрог нийт нутаг дэвсгэрийн 9,35 %-ийг эзэлнэ. Энэхүү бүсийн ургамалжилт нь цөлөрхөг хээрийн ба хөрсний хувьд цөлийн хэв шинжид хамаарна.

Ургамалжилтын хувьд тачирхан сийрэг ургамалтай, өдлөг хялганат, өдлөг хялгана-хазаарганат, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт цөлөрхөг хээр зонхилно.

Тус бүс нутаг цөлийн болон цөлөрхөг хээрийн онцлогийг бүрэн илтгэсэн нэлээд онцлогтой. Энд Монгол орны болон төв Азийн унаган, үлдвэр, ховор нэн ховор, эмийн гоц ашигт ургамлууд нэлээдгүй ургадаг. Цөлөрхөг хээрийн бүсэд нийт 705 зүйл ургамал бүртгэгдсэнээс 612 зүйл нь өвслөг, 93 зүйл мод, сөөг ургамал байна. Цөлөрхөг хээрийн ургамлын бүлгэмдэлд сөөг, сөөгөнцөр ургамлын үүрэг их. Мөн зуны тур зуурын хур тунадсыг шүтэн нэг ба хоёр наст ургамал түлхүү ургана.

Судалгаа явуулсан нутаг буюу төслийн талбай орчим шарилж-харганат бүлгэмдэлтэй. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 8-10 %, зүйлийн бүрэлдэхүүн 10 м² талбайд 4-8 зүйл ургамал тархаж, бэлчээрийн ургац 0.5-1.2 ц/га.



Зураг 11. Төслийн талбайн ургамалжилт

Амьтны аймаг: Төсөл хэрэгжих талбай нь монгол орны байгалийн бүс бүслүүрийн мужлалаар Дорнод говийн тойрогт хамаарна. Төслийн талбайн район амьтны аймгийн хувьд ядмаг, зүйлийн бүрдэл цөөн, суурин амьдрах зүйлүүд дотор бүс нутгийн хэмжээнд ховордсон амьтан байхгүй.

